



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: secretariat@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.03.24 № 411-01/2911
танай _____-ны № _____-т

Улсын Их Хурлын гишүүдийн асуулт хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдааны Улсын Их Хурлын асуулгын цагаар Ерөнхий сайдад тавих Улсын Их Хурлын гишүүдийн асуултыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2-т "Гишүүд Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурлын даргад бичгээр хүргүүлэх бөгөөд ирүүлсэн асуултыг нэгтгэн Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдад ажлын 2 өдрийн дотор хүргүүлж, асуултыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулна." гэж заасны дагуу хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГА



Н.УЧРАЛ

2026000008

Монгол Улсын Их Хурлын 2026 оны
03 дугаар сарын 27-ны өдрийн
хурал дугаар албан бичгийн
хавсралт

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сарын 27-ны өдрийн Баасан гарагт болох Улсын Их Хурлын асуулгын цагт Ерөнхий сайдаас асуухаар ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүдийн асуулт

№	Улсын Их Хурлын гишүүн	Асуулт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ МОНГОЛ АРДЫН НАМЫН БҮЛЭГ		
1	Д.Ганмаа	Хууль тогтоомжийн биелэлтийн хүрээнд: Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэгт “Ажил олгогч, хуулийн этгээд дотооддоо хэрэгжүүлэх байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана” гэж, 52 дугаар зүйлийн 52.7 дахь хэсэгт “Хуулийн этгээд өөрийн цалингийн нийт сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр хүүхэд хамгааллын бодлого, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахад зарцуулна.” гэж заасан. Үндсэндээ хүүхэд хамгааллын бодлогыг бүх төрлийн байгууллага баталж, хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын тухай 24 дэх илтгэлдээ үе тэнгийн дээрэлхэлт, хүүхдийн хүчирхийлэл цахим орчинд эрчимтэй шилжсэнтэй холбоотойгоор цахим орчинд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх асуудлыг хөндсөн. Үүнд: Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан бүх шатны боловсролын байгууллага, насан туршийн суралцахуйн төв, сүм, хийдийн шашны сургууль, хүүхэд хамгааллын бодлого түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх, хуулийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулалтын арга хэмжээг авч хяналт тавих гэж бий. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд хэдэн байгууллага, хуулийн этгээд хүүхэд хамгааллын бодлого батлуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа вэ? Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих механизмыг хэрхэн бүрдүүлэх вэ?
2	Г.Лувсанжамц	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд: 1.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 158 дугаар тогтоолоор 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан, УИХ-ын 2024 оны 08 сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй хэрхэн уялдаж хэрэгжихээр төлөвлөгдсөн, мөн бодит үр дүнг хэмжих ямар хэмжигдэхүйц зорилт, шалгуур үзүүлэлтүүд (KPI) тусгагдсан бэ? 2.”Боловсролыг дэмжих жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга

		хэмжээ, төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор 2026 оны улсын төсөвт ямар хэмжээний санхүүжилт тусгагдсан, энэ нь шинэ бодлого, санаачилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх, эсвэл өмнөх үйл ажиллагааг өргөтгөсөн хэлбэртэй байгаа эсэх талаар мэдээлэл өгнө үү. 3."Боловсролыг дэмжих жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ, бодлогын үр дүн багш, суралцагч нарт ямар бодит өөрчлөлт, үр дүн авчрахыг хэрхэн тодорхойлж, хэмжихээр төлөвлөсөн талаар мэдээлэл өгнө үү. 4.Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн хүрээнд хэрэгжих "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах-2 дахь нэмэлт" төслийн 130.0 ам.долларын санхүүжилтээр баригдахаар төлөвлөсөн 32 сургууль, 9 цэцэрлэгийн жагсаалт буюу байршлыг шинэчилсэн эсэх, хэрэв шинэчилсэн бол ямар шалгуур, үндэслэлд тулгуурлан өөрчлөлт оруулсан, мөн эдгээр өөрчлөлт нь бодит хэрэгцээ, ачааллын судалгаатай хэрхэн нийцэж байгаа талаар мэдээлэл өгнө үү.
3	Д.Энхтүвшин	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн "3.2.2.4. Төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн нэгдсэн платформыг эхлүүлнэ." гэж заасан. Зөвшөөрлийн нэгдсэн платформ ашиглалтанд орсон боловч зарим төрийн байгууллагууд одоо болтол нэгдэхгүй байна. Эдгээр байгууллагуудыг зөвшөөрлийн нэгдсэн системд хэзээ бүрэн холбох вэ? Мөн хөтөлбөрийн 3.2.2.15-т "Экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний гадаад экспортыг нэг цонхны бодлогоор дэмжинэ." гэсэн зорилтын хүрээнд хийгдэж буй ажлуудын талаар мэдээлэл өгөхийг хүсье. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хавсралт 2-ын 13-т заасан "Зах зээл дэх төрийн оролцоог бууруулах" зорилтын хүрээнд хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувийг 2023 онд 76.2 хувь байсныг, жил бүр нэг хувиар нэмэгдүүлж 2028 онд 80 хувьд хүргэх зорилтыг тавьсан. 2025 онд энэ үзүүлэлт хэдэн хувьд хүрсэн бэ? Энэ зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хийхээр төлөвлөж байгаа арга хэмжээнүүд?
ХҮН НАМЫН ЗӨВЛӨЛ		
4	П.Ганзориг	1. Макро эдийн засаг болон төсвийн талаар: - Дэлхийн геополитикийн нөхцөл байдлын асуудалтай холбоотой Монгол Улсын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллүүд юу байна вэ? Үүнтэй холбоотой ямар бодлого баримталж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ? - 2026 оны төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн төсөөлөл; - Инфляц (шатахууны үнэ), иргэдийн бодит орлогыг тогтвортой байлгах, хамгаалах тал дээр хэрэгжүүлж

		буй бодлого, чиглэл 2. Зээлийн хүүг бууруулах асуудлын талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн талаар: - Тухайлбал банкны салбарын төвлөрөл өндөр байгаа нь хүү буурахгүй байх нэг шалтгаан болж байна. Өрсөлдөөнийг нэмэгдүүлэхийн тулд гадаадын банк оруулах, эсвэл зах зээлийн бүтэц өөрчлөх бодлого бий юу? Хэзээнээс хэрэгжиж эхлэх вэ? 3. Үндэсний баялгийн сангийн хөрөнгийг улс төрөөс ангид байлгаж, мэргэжлийн удирдлагын тогтолцоонд шилжүүлэн үр өгөөжтэйгөөр өсгөх чиглэлээр Засгийн газар хэзээнээс, ямар үе шаттайгаар ажиллаж эхлэх вэ? - Мөн УИХ-аас баталсан "Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 120 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой хэлэлцээрийн үйл явц одоогоор ямар шатанд явж байна вэ? Тус хэлэлцээрээс гарах бодит үр дүнг хэзээнээс гарах вэ?
ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ		
5	Н.Номтойбаяр	Монгол Улсын эдийн засаг өсөж байна гэж Засгийн газар мэдээлж байгаа ч бодит байдал дээр энэ өсөлтийн үр өгөөж хэдэн хувьтай байна вэ? Тэгвэл олонх иргэд эдийн засгийн өсөлтөөс яагаад хүртэж чадахгүй байна вэ?

---oOo---